



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2012 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 169

Улаанбаатар хот

“Номин даатгал” ХХК-д дүрмийн сан  
/хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн  
хэмжээндээ өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 21.3.2, 21.5, 22.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг тогтоох тухай” 333 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:


1. “Номин даатгал” ХХК-ийн дүрмийн сан /хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн хэмжээг тус компанийн 2011 оны хуримтлагдсан ашгаас нийт 500,000,000.0 /таван зуун сая/ төгрөгөөр нэмэгдүүлж дараахь байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:

	Хувь нийлүүлэгч	Хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь
		Эхний үлдэгдэл	Нэмэлт хөрөнгө оруулалт	Эцсийн үлдэгдэл	
1	А.Шагдарсүрэн	1 000 000 000.0	500 000 000.0	1 500 000 000.0	100 хувь
	Дүн	1 100 000 000.0	500 000 000.0	1 500 000 000.0	100 хувь

2. Дүрмийн сан /хувь нийлүүлсэн хөрөнгө/-ийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримтыг 2012 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Номин даатгал” ХХК /С.Ганчимэг/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллах, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН